



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Г Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа Г  
эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг  
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хаан даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 860,000,000.00 /найман зуун жаран сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдийн бүтцийг энэхүү тогтоолын хавсралтад дурдсанаар өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Хаан даатгал” ХХК /Ж.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2018 оны 02 сарын 28 өдрийн  
23 тоот тогтоолын хавсралт



“ХААН ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10 000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Ж.Баярсайхан	125,000	1,250,000,000.00	34%	76,000	760,000,000.00		201,000	2,010,000,000.00	44,08%
2	Г.Энхбилэг	145,000	1,450,000,000.00	39%				145,000	1,450,000,000.00	31,80%
3	Ч.Чимэдсүрэн	60,000	600,000,000.00	16%				60,000	600,000,000.00	13,16%
4	А.Мэндбаяр	25,000	250,000,000.00	7%	10,000	100,000,000.00		35,000	350,000,000.00	7,67%
5	Г.Лхагва-Очир	15,000	150,000,000.00	4%				15,000	150,000,000.00	3,29%
	<b>Нийт</b>	<b>370,000</b>	<b>3,700,000,000.00</b>	<b>100%</b>	<b>86,000</b>	<b>860,000,000.00</b>		<b>456,000</b>	<b>4,560,000,000.00</b>	<b>100%</b>